Гүйцэтгэх захирлын 2024 оны
02 дугаар сарын 15-ны өдрийн
24/006 дугаар тушаалын
Хавсралт №8

Хамрах хүрээ:Нийт ажилтанууд	*Хариуцах газар: ЗХНГ*
Батлагдсан огноо:2024.02.15	*Танилцах: МШНГ, УБГ, БМГ*
Хувийг хадгалах: ЗХНГ, МШНГ, УБГ, БМГ	*Хуудасны тоо:3*

НИЙТЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОДЛОГО

НЭГ. ЕРӨНХИЙ БОДЛОГО

"Медиа групп" ХХК-ийн / цаашид компани гэх / NTV телевиз, ONTV телевиз, ФМ-107 радио, Time.mn цахим хуудас болон бусад сувгууд, тэдгээрийн өдөр тутмын үйл ажиллагаа нь улс төрийн аливаа нам, бүлэг, хувь хүний явцуу эрх ашгаас ангид байж олон нийтийн төлөөх хэвлэл мэдээллийн байгууллага байхад чиглэгдэнэ.

ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1 Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх

2.2 Төрт ёс, түүх, соёл, хэл бичгийн уламжлал, үндэсний үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх

2.3 Хүн төрөлхтний соёл иргэншлийн ололт, өв, үнэт зүйлсийг хүндэтгэх

2.4 Улс төр, шашин, нийгэм, эдийн засгийн олон ургалч үзэл бодлыг хүндэтгэх

2.5 Төр, шашны байгууллага, улс төрийн нам, хувь хүний эрх ашгаас хараат бус, бие даасан байх

2.6 Хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлж, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөх

2.7 Олон нийтийн нийтлэг эрх ашигт нийцсэн, тэнцвэртэй, бодит мэдээ, мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх

2.8 Урам зориг өгөх түүхүүдийг түгээх, эерэг хандлагыг бий болгоход чухал үүрэгтэй гэдгээ ухамсарлах

2.9 Хүүхэд, залуучуудын хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөхгүй байх

2.10 Өргөн нэвтрүүлгийг эзэмшлийн хэт төвлөрлөөс хамгаалах, зах зээлийн өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлж, өргөн нэвтрүүлгийн салбарын хөгжлийг дэмжин хөгжүүлэх

2.11 Үндэсний бүтээлийг дэмжин хөгжүүлэх

2.12 Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээнд харшлахгүй байх

ГУРАВ. СЭТГҮҮЛЧ, УРАН БҮТЭЭЛЧДИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ

3.1 Сэтгүүлч, уран бүтээлчид Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг баримталж ажиллана.

3.2 Монгол Улсын Үндсэн Хууль, түүгээр олж авсан хүний язгуур эрхийг эрхэмлэж түүнийг хамгаалахын төлөө одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль, тогтоомжид захирагдаж ажиллана.

3.2 Сэтгүүлч, уран бүтээлчид нь "Нийтлэлийн ерөнхий бодлого"-ын 1.1дахь хэсгийг чанд баримтлан ажиллахын дээр өөрийн бэлтгэх сэтгүүлзүйн бүтээлдээ илүү шинэлэг, мэргэжлийн чиг баримжааг сонгохыг эрмэлзэнэ.

ДӨРӨВ. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

4.1 Редакцын бэлтгэсэн сэтгүүлзүйн бүтээл болон нэвтрүүлэгийн /телевиз, сайт, цахим сүлжээ/ уншигч, үзэгчдийн бичсэн сэтгэгдэлд иргэний сэтгүүл зүйг хүндэтгэн үзэж холбогдох, хуулийн байгууллага, хувь хүн, байгууллага, иргэдийн гомдлыг хүлээн авч барагдуулахаас өөрөөр хариуцлага хүлээхгүй.

4.2 Редакц өөрсдийн бэлтгэсэн, нийтэлж, нэвтрүүлсэн сэтгүүлзүйн бүтээлүүдийнхээ мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй.

ТАВ. ХҮҮХДИЙГ ЗОХИСГҮЙ АГУУЛГААС ХАМГААЛАХ

5.1 Хүүхдийг эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд тэгш оролцох хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, үндэсний уламжлалт зан заншил, ёс суртахуун, үнэт зүйлд тулгуурлан хүүхдийн нас бие, сэтгэхүйн хөгжлийн онцлогт тохирсон, мэдээллээр хангах зарчмыг баримтална.

5.2 Хүүхэд залуусын сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх гэдэгт дараах агуулга бүхий нэвтрүүлэг, бүтээл, зар суртчилгаа хамаарна;

5.2.1 Хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлөх хараалын болон бүдүүлэг үг хэрэглэх

5.2.2 Хүүхдийн эмзэг байдлыг ашиглан хүнд хөдөлмөр эрхлүүлэх, худалдаалах тусгаарлан хорих, цус, эд эрхтний авахыг харуулах, бусад эрсдэлт үйл ажиллагаанд уруу татах зэргээр хүүхдийн айдас, цочролд автуулах

5.2.3 Хүүхдийн зан үйлд сөргөөр нөлөөлөх, бусдыг айлган сүрдүүлэх, зодох, дооглох, тохуурах, гадуурхах, бүлэглэн гадуурхах, нэр хоч өгөх зэргээр ичээх, гутаах, доромжлох,

5.2.4 Хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлөх зан үйл болох бусдыг хүйс, яс үндэс, арьс өнгө, хөгжлийн бэрхшээл, нийгмийн гарал зэргээр ялгаварлан гадуурхах

5.2.5 Хүүхэд залуусын сэтгэхгүйд сөргөөр нөлөөлж цочролд оруулж болзошгүй золгүй явдал, осол, гамшиг, гэмт хэргийн улмаас хохирогчийн цогцос, их хэмжээний цус, тасарсан эд эрхтэн, шашны харгис зан үйл, шашны зүй бус номлолыг нэвтрүүлэх.

5.2.6 Хүүхэд залуусын сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх агуулгыг тодорхойлохдоо тухайн үзэгдлийн давтамж, хугацаа, үндсэн агуулга, уран сайхны болон зөгнөлт хэлбэрээр дүрсэлсэн эсэхийг харгалзан үзнэ.

5.3 Хүчирхийлэл, садар самууныг сурталчлах гэдэгт дараах агуулга бүхий нэвтрүүлэг, бүтээл, зар сурталчилгаа хамраана.

5.3.1 Зодох, цохих, өшиглөх, хазах, түлэх, сэгсрэх, чимхэх зэрэг ямар нэгэн байдлаар хүний бие махбодын гэмтэл учруулах үйлдлийг харуулах

5.3.2 Хүнийг байнга голох, доромжлох, нэр хүндийг нь гутаах, хүний эрхийг үгүйсгэх гэх мэтээр өөртөө итгэх итгэл, нийгмийн чадамжаа хүүхэд аажмаар гээхэд хүргэж, байгаа сөрөг зан үйл бүхий сэтгэл санааны хүчирхийллийг агуулах

5.3.3 Бэлгийн амьдралыг ил тод харуулах, бэлгийн харилцаанд орох, уруу татах, биеийг нь үнэлүүлэх үйлдлийг харуулах, эротик бүтээл үзүүлэх зэргээр садар самууныг сурталчлах

5.3.4 Бэлгийн харьцаа хандлагаар өдсөн тоглоом тоглох, шалиг үг яриа ярих зэргээр бие авч явах, бусад тийм боломж олгохыг харуулах.

5.3.5 Бэлгийн хүчирхийллээс бусад хүний амь нас, эрүүл мэндийг хохироох үйл явцыг бодит байдлаар харуулалгүйгээр, сөрөг хандлага, харгислал, хүчирхийллийг буруутгасан бол зохисгүй агуулга гэж үзэхгүй.

5.4 Гэмт хэргийн үйлдлийг нарийвчлан зааварчилсан бүтээл гэдэгт дараах агуулга бүхий нэвтрүүлэг, бүтээл, зар сурталчилгаа хамаарна.

5.4.1 Зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл байгуулах, түүнд элсэх тухай мэдээлэл өгөх, зэвсэгт үймээн дэгдээх болон хорлон сүйтгэх ажиллагааг төлөвлөх зэрэг гэмт хэргийн шинжтэй үйлдлийг нарийвчлан зааварчлах.

5.4.2 Хүүхдийн эрүүл мэндэд хохирол учруулах амиа хорлохыг харуулах, хэрхэн амиа хорлох тухай зааварчлах

5.4.3 Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх, бэлтгэхийг харуулах

5.4.4 Мөрийтэй тоглоом тоглохыг уриалах

5.4.5 Дайн байлдаан, тулааныг хэрцгийгээр харуулсан цахим болон гар утасны тоглоомын тухай нэвтрүүлэг.

5.5 Хар тамхи, сэтгэхүйд нөлөөлөх эм бэлдмэл бэлтгэн боловсруулах, хэрэглэхийг, бүтээл, зар сурталчилгаа хамаарна.

5.5.1 Согтуурсан, мансуурсан байдлыг харуулах

5.5.2 Мансууруулах үйлчилгээ бүхий ургамал, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэн боловсруулах, хэрэглэхийг харуулах

5.5.3 Ахуйн хэрэглээний зориулалттай газ, цавуу, будаг шингэлэгч, бензин, ариутгалын бодисыг зориулалтын бусаар хэрэглэхийг харуулах

5.5.4 Архи, тамхины хэрэглээг сурталчлах

5.6 Нийгмийн эсрэг үйл ажиллагааг өдөөхгүйгээр хар тамхи мансууруулах бодисыг дурдах, сэтгэцэд нөлөөт болон мансууруулагч бодисуудын сөрөг нөлөөг тайлбарлах, буруушаасан хандлагыг илэрхийлсэн бол зохисгүй агуулга гэж үзэхгүй.

5.7 Компанийн бүхий л үйл ажиллагаанд 5.2-5.6-д дурдсан зарчмыг мөрдөж ажиллана.

ЗУРГАА. ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭ

6.1 Компани нь олон нийтийн сүлжээгээр өөрийн контентуудаа түгээх ба сэтгүүл зүйн ёс зүйн зарчмыг баримтлан албан ёсны хуудсуудаар мэдээлэл түгээнэ. Албан ёсны хуудсууд нь Facebook, Twitter, Youtube, Instagram зэрэг олон төрлийн цахим сүлжээнд байж болох бөгөөд компаний өмч байна.

6.2 Ажилтнууд нь хувийн зүгээс хөтлөн явуулдаг олон нийтийн сүлжээний хаягуудаар үзэл бодлоо Компаниас хараат бусаар, чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Ингэхдээ өөрийн хаягны танилцуулгад Компаний лого, нэвтрүүлгийн нэр, зураг зэргийг ашиглахгүй ба “views are my own” буюу энд байгаа постууд нь миний хувийн үзэл бодол болно гэсэн тайлбарыг оруулна.

6.3 Ажилтан нь хэдий өөрийн хувийн цахим сувгаар боловч Компани болон редакцын бодлоготой нийцэхгүй мэдээ мэдээлэл түгээх бол Компанийн байр суурийн хүндэтгэж үзнэ.

6.4 Ажилтнуудаа шашин шүтэх эрх чөлөөтэй, иргэний хувьд улс төрийн өөрийн үзэл бодол, сонголттой байхыг хүлээн зөвшөөрнө. Гэвч энэ бүх эрхээ эдлэх, үзэл бодлоо илэрхийлэхдээ компанийн байр сууринаас илэрхийлэхгүй, мөн тийм байдлаар харагдахгүй байхад анхаарна.

6.5 Олон нийтийн сүлжээн дэх Ажилтны хувь хүний үзэл бодол нь нийт байгууллага хамт олон болоод компанийн редакцын нийтлэг эрх ашгийн төлөөлөл болохгүй.

ДОЛОО. ХАРААТ БУС БАЙДАЛ БА ЗАР СУРТАЛЧИЛГАА

7.1 Редакц нь төр, захиргааны болон бизнесийн байгууллага, хувь хүн, албан тушаалтны үйл ажиллагааг сурталчлах мэдээлэл түгээх тал дээр нээлттэй, бизнесийн хамтын зарчим барьж ажиллана.

7.2 Хамтран ажиллагч төр, захиргаа болон бизнесийн байгууллага, хувь хүн,албан тушаалтан нь Компанийн нийтлэлийн бодлогод хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх эрхгүй ба Компанид шахалт үзүүлэх, ашиг сонирхлын харилцаа үүсгэхийг хатуу хориглоно.

Ерөнхийлөгч, УИХ, Орон нутаг зэрэг бүх шатны сонгуулийн сурталчилгааг хуульд заасанд хугацаанд төр захиргааны байгууллага, улс төрийн нам, эвсэл, бие даагч, нэр дэвшигчидтэй ижил тэгш, нээлттэй зарчмаар хамтран ажиллана.

НАЙМ. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ

8.1 Компанийн удирдлагын багийн хурлаар хэлэлцэн редакцын бодлогод нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд уг нэмэлт, өөрчлөлтийг Гүйцэтгэх захирлын тушаалаар тухай бүр баталж, нийт ажилтнуудад танилцуулж байна.

8.2 Бодлогын хэрэгжилтэд Захиргаа, хүний нөөцийн газар хяналт тавьж ажиллахын зэрэгцээ сайжруулах, хүчингүй болгох зүйл, заалтуудыг бүртгэж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг тухай бүр оруулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.